

ГЕОЛОГИЙН НЭР ТОМЪЁОНЫ ТУХАЙД

Ж.БЯМБА

Монголын стратиграфын комиссын
нэр томъёоны бүлэг

МУИС, ШУТИС, Дарханы техникийн коллеж зэрэг геологийн мэргэжлээр боловсон хүчин бэлтгэдэг сургуулиудад геологийн шинжлэх ухааны нарийн төвөгтэй хичээлүүдийг монгол хэл дээр заадаг болоод 40 гаруй жил болж байна.

Геологичид бид үндэснийхээ хэл дээр геологийн тайлан, ном, зохиолоо бичдэг болсон нь том амжилт билээ. Энэ бүгд бол монгол үндэстэн геологич хүнд геологийн сэтгэлгээ буй болж хөгжиж байна гэсэн үг юм.

Геологийн шинжлэх ухааны нэр томъёог монгол хэлэнд буулгахдаа юуны түрүүнд уг нэр томъёоны агуулгыг алдагдуулахгүй хадгалан үлдэхийг эрмэлзэх ёстой. Гэсэн хэдий боловч хэт орчуулснаас үндэсний монгол хэлээр бичигдсэн геологийн ном, тайлан, ойлгогдохгүйд хүрч ардаа тайлбар тольтой бичигддэг болж байна.

Геологийн нэр томъёо бол ихэвчлэн латин, грек, итали, франц, англи, хааяа орос гаралтай байгаа нь олон улсын чанартай болохыг харуулж байгаа билээ. Нэгэнт олон улсын чанартай юм бол геологийн нэр томъёог орчуулаад хэрэггүй гэсэн нэг хэсэг геологичид байхад, орчуулах ёстой монгол хэлний үгийн баялаг их. Тийм учраас геологийн нэр томъёог үндэснийхээ хэлээр бичих ёстой гэсэн нөгөө хэсэг байна.

Ардчилалыг буруу ойлгосон геологичид маань бараг хүн болгон өөрийн гэсэн геологийн хэлтэй болжээ. Тийм ч учраас тэдгээрийн бичсэн тайлан өөртөө болон өөр бусад уншигчдад ойлгомжтой болгохын тулд ардаа орчуулгын хадмал нэр томъёотой гарч байгаа нь сайшаалтай биш юм. Нөгөө хэсэг геологичид нь геологийн нэр томъёоны учир олдохоо болилоо. Замбараагаа алдлаа. Яаж бичих юм бэ. Хэлээд өгөөчээ гээд салбарынхаа удирдлагуудад хүсч байх юм.

Үүний хамт Ж.Бямбын ерөнхий редактороор 8000 орчим үгтэй геологийн нэр томъёоны Орос-Монгол-Англи толь хэвлэгдэн гарснаас хойш 10-аад жил болж байгааг бүгд мэдэж байгаа. Энэ толийг бүтээхэд Ж.Лхамсүрэн, Ө.Жамъяндорж, Д.Гарамжав, Г.Жамсрандорж, П.Хосбаяр, Ч.Минжин нарын манай геологичидын дотроос нэр томъёогоор нилээд идвэхтэй ажиллаж ирсэн ахмад, эрдэм номтой,

туршлагатай геологичид оролцсоныг тэмдэглэх хэрэгтэй. Миний бодож байгаагаар энэ толийг салбарын хэмжээгээр мөрдүүлэх ёстой. Гэтэл "өөрийнх" нь хэлээр орчуулаагүй эсвэл огт орчуулаагүй болохоор уг толийг авч хэрэглэхгүй байгаа нь гайхалтай. Дахиж толь зохионо гээд бодож суудаг эрдэмтэн-геологич нар ч бас ойлгогдохгүй байна. Мөхөс миний бодож байгаагаар бол "Улаан" толио боловсронгуй болгох ёстой. Үг нэмэх шаардлагатай бол нэмэх хэрэгтэй. Зарим үгийг орчуулах ёстой бол орчуулах, аль эсвэл орчуулахгүй ёстой байсан бол буцааж сэргээе. Энэ ажилд хавьгүй бага цаг, зав ба мөнгө зарцуулагдана гэдгийг мартаж болохгүй.

Монгол хэлэнд орж ирж байгаа гадаад үгэнд (нэр томъёонд) доорхи хүндрэлүүд байна.

1. "ия" ба "а"-гаар төгссөн орос голдуу галигтай гадаад нэр томъёоны "я" үсгийг нь хасаад эсвэл тэр чигээр нь авч хэрэглэж байгаа явдал нь дагавар залгахад нилээд хүндрэл учруулж байна. Жишээлбэл; "серия" гэдэг үгийг "сери" гэж авч хэрэглээд дагавар залгахад сериүд, сериэс гэх мэт болж байна.

2. Өөр нэг жишээ бол тэр чигээр нь авч хэрэглэж байгаа "Структура" гэдэг үгийг дуудахдаа орос дуудлагаар нь "Структүүр" гэж дуудсан мөртлөө "Структура" гэж бичих жишээтэй. Энэ үгэнд структуратай (эсвэл структуртай) гэж бичиж байгаа мөртлөө стрүктүүртэй гэж тэс өөрөөр уншиж ойлгох жишээтэй. Бид чинь оросоор биш монголоор бичиж, ярьж байгаа шүү дээ.

3. "У" үсэгтэй гадаад нэр томъёог уншихдаа монгол "Ү" үсгээр дуудаж байна. Энэ нь монгол хэлний дуудлагаар бичдэг онцлогтой зохицохгүй байна. Жишээлбэл; субдукция (Subduction) гэдэг үгийг сүбдүкц гэж уншихаас өөр замгүй байна.

Энд нэг сонирхолтой зүйл бол гадаад хэлний өргөлттэй эгшгийг монгол хэлэнд буулгаж тэр чигээр нь хэрэглэж болвол урт эгшиг хэрэглэхээс өөр аргагүй болж байна. Жишээлбэл; "Структур" гэдэг үгийг "Структүүр", "Текстур" гэдэг үгийг "текстүүр" гэж монгол хэлэнд буулгах нь илүү ойлгомжтойгоос гадна монгол хэлний дагавар залгахад хялбар эвтэйхэн юм. Утга, агуулга нь ч алдагдахгүй.

4. "Сумка", "Дежурный" гэдэг гадаад үгнүүд монгол хэлэнд "Цүнх", "Жижүүр" гэдэг монгол үгнүүд болоод хэвшчихжээ. Түүний нэг адил зарим "фация", "формация" гэдэг үгнүүдийг "фаад", "формаад" гэж монгол дуудлагаар

нь нэрлэж явбал илүү ойлгогдохсон. Тэгээд ч агуулга нь алдагдахгүй байхад эгшиг зохицох дүрмэнд таарахгүй “а” ба “и” хоёрыг нэг үгэнд бичих гээд байдгийн учир ойлгогдохгүй байна. Эр, эм эгшиг нэг үгэнд зэрэг байгаа үгнүүдэд дагавар залгахад хүндрэлтэй “фаци”, “формаци” гэх мэт хэлбэрлүү оруулах нь бас л нэг завсрын хүндрэл учруулж байна. Энэ бол Ц.Дамдинсүрэнгийн дүрмийг сохроор татаж байгаагийн нэгэн хүндрэл.

5. Ер нь өргөлттэй эгшиг болгоныг урт эгшгээр сольё гэж бас болохгүй. Аль болох цөөхөн үгийг урт эгшигтэй байлгахыг эрмэлзэх хэрэгтэй гэж бодож байна. Жишээ болгон “интрузия” гэдэг үгийг “интруз”, “эффузия” гэдэг үгийг “эффүз” гэж бичвэл заавал урт эгшиггүйгээр монгол нэр томъёо болгож болох юм.

Иймээс геологийн гадаад нэр томъёог монгол хэлэнд буулгахдаа урсгалаар биш түүнийг хэлнийх нь үүднээс цаашид хэрхэн хэрэглэж болох эсэх, бас нэг чухал зүйл бол шинжлэх ухааны агуулгыг нь алдагдуулахгүй байхыг чухалчилбал зохино.

Зориуд тэмдэглэн хэлэхэд эрдэс болон чулуулгийн нэрийг аль болохоор орчуулахгүй байхыг эрмэлзэх хэрэгтэй. Гэхдээ хэвшиж байгаа боржин, элсжин, шохойжин зэргийн цөөн хэдэн нэр томъёог битгий хэрэглэ гэж байгаа юм бишээ.

Хэл хөгждөг. Урагшаа явдаг. “Улаан” толийг гарснаас хойш юуны түрүүнд уг толинд орсон нэг хэсэг үгс хэрэглэгддэг болсон. Нэг хэсэг үгс огт хэрэглэгдэхгүй байгаа. Арай өөр орчуулгаар ч юм уу, эсвэл орчуулахгүйгээр ч юм уу үлдээсэн үгнүүд бага хэрэглэгдэж байгаа. Огт хэрэглэгдэхгүй үг ч байж болох юм. Үүнээс сургамж аваад “Улаан” толио боловсронгуй болгох хэрэгтэй мэт санагдана.

Энд жишээ болгон цөөн хэдэн гадаад нэр томъёог монгол хэлэнд орчуулахгүйгээр хэрхэн буулган хэрэглэж байгаагаа толилуулав. Үүнд;

1. Структүүр	11. Стратиграф	21. Мааньт
2. Текстүүр	12. Горизонт	22. Маагм
3. Обдукц	13. Ярус	23. Дивергент зааг
4. Сүбдукц	14. Террейн	24. Конвергент зааг
5. Сүтүр	15. Фаун	25. Конвекц
6. Формаац	16. Флор	26. Сүбвулкан
7. Фаац	17. Лаав	27. Түрбидит
8. Фааз	18. Түф	28. Меланж
9. Интруз чулуулаг	19. Коллиз	29. Меланократ
10. Эффүз чулуулаг	20. Аккреп	30. Лейкократ г.м.

Хэдийгээр геологичид маань цөөхөн ч гэсэн олон олон үеийн геологичид төрж байна. Гэтэл бид тавхан үгэн дээр маргаад л сууж байдаг. Дундыг баримтлаад л. Болохгүй байхад нь болж байна гээд алийн болгон мэдэн будилж байхав дээ. Геологийн ном зохиолыг монгол хэл дээр бичиггээе. Гэхдээ олон улс нийтээр хэрэглэдэг болсон нэр томъёог бид заавал орчуулах гэж цаг заваа үрээд хэрэггүй биз дээ.

Геологийн нэр томъёо бол ганц нэг хүний хувийн асуудал биш. Энэ бол нэг талаас олон геологичдийн мэргэжлийн өсөлт хөгжлийг өөд нь татахад хялбар нөгөө талаас геологийн шинжлэх ухаантай холбоотой байгалийн бусад шинжлэлтэй ургуулан бодож, харьцуулан ойлгоход тус дөхөм болох амин чухал түлхүүр байх ёстой.